



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Хуульчдын гудамж 13/1, Утас: 32-80-30, Факс: (976-11) 32-07-16
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2014 . 04 . 29 № 1/615

танай _____-ны № _____-т

Чиглэл хүргүүлэх тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын “Цалин нэмэгдэл тогтоох, хөнгөлөлт эдлүүлэх, ажилласан жилд оруулж тооцох тухай” 2014 оны А/83, А/44 дүгээр хамтарсан тушаалыг хавсралтаар хүргүүлэв.

Уг хамтарсан тушаалыг үндэслэн “Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох хууль”-д хамрагдан бүртгүүлж, ажилласан жил нөхөн тооцуулсан иргэдийн хувьд нийгмийн даатгалын сангаас тэтгэмж олгохдоо дараах чиглэл баримталж ажиллахыг үүрэг болгож байна.

Үүнд:

1. “Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох хууль”-иар 1990 оны 01 дүгээр сарын 01-ээс 1994 оны 12 дугаар сарын 31-нийг хүртэл хугацааг нөхөн тооцуулж шимтгэл төлсөн хугацаанд оруулан батламж авсан даатгуулагч болон уг хугацаагаар тэтгэвэр, тэтгэмж тогтоолгосон тэтгэвэр авагч нас барвал түүнд “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-ийн 20 дугаар зүйлд заасны дагуу оршуулгын тэтгэмж олгоно. Өөрөөр хэлбэл 1990 оны 01 дүгээр сарын 01-ээс 1994 оны 12 дугаар сарын 31-нийг хүртэлх хугацаа нь шимтгэл төлсөн хугацаанд тооцогдоно.

2. Мөн “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-ийн 17 дугаар зүйлийн 1, 19¹ дүгээр зүйлийн 1-д заасан ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдахаас өмнөх болон жирэмсний чөлөө авахаас өмнөх шимтгэл төлсөн хугацаанд 1990 оны 01 дүгээр сарын 01-ээс 1994 оны 12 дугаар сарын 31-нийг хүртэл хугацааг оруулан тооцно.

Монгол Улсын Хөдөлмөрийн сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын “Цалин нэмэгдэл тогтоох, хөнгөлөлт эдлүүлэх, ажилласан жилд оруулж тооцох тухай” 2014 оны А/83, А/44 дүгээр хамтарсан тушаалыг мөрдөж ажиллах, ажил олгогч, даатгуулагчдад сурталчлах ажлыг зохион байгуулж ажиллах нь зүйтэй.

Хөдөлмөрийн сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын “Цалин нэмэгдэл тогтоох, хөнгөлөлт эдлүүлэх, ажилласан жилд оруулж тооцох тухай” 2014 оны А/83, А/44 дүгээр хамтарсан тушаалын хуулбарыг хавсаргав.

Хавсралт 1 хуудастай.

ДАРГА



Ц.УРТНАСАН

МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН САЙД,
ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2014 оны 04 дугаар
сарын 15 ны өдөр

Дугаар А/83 А/НН

Улаанбаатар хот


Цалин, нэмэгдэл тогтоох, хөнгөлөлт
эдлүүлэх ажилласан жилд оруулж
тооцох тухай

Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан шалтгаанаар 1990-1995 оны хооронд ажил хөдөлмөр эрхлээгүй буюу эрхлэх боломжгүй байсан хугацааг ажилласнаар нөхөн тооцуулсан иргэд хөдөлмөрийн харилцаанд шинээр орсноос үүсч буй зарим асуудлыг Хөдөлмөрийн болон Төрийн албаны тухай хуулийн холбогдох зүйл, заалтын хүрээнд зохицуулах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Даатгуулагчийн ажилласнаар нөхөн тооцуулсан 1990-1995 оны хооронд дахь хугацааг нийт ажилласан болон төрийн албанд ажилласан хугацаанд оруулж, тухайн ажилтны үндсэн цалин, нэмэгдлийн хэмжээг тогтоох, аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны ээлжийн амралтын хоногийг тооцоход харгалзан үзсүгэй.

2. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөрийн яамны Хөдөлмөрийн харилцааны бодлого, зохицуулалтын газар /Б. Алимаа/, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Л. Мөнхзул/-т даалгасугай.

3. Энэхүү тушаалыг 2014 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдсүгэй.

ХӨДӨЛМӨРИЙН САЙД

Я. САНЖМЯТАВ

ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД

С. ЭРДЭНЭ